

Өлгий сумын 6 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

## БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өлгий сумын 6 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2025/071/НА-СТА-ТШЗ

|  |  |
|--|--|
| Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a><br>Өлгий хот<br>2025 он | Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын<br>дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл<br>Утас: 70422954 Цахим хаяг: <a href="mailto:aigulj@audit.gov.mn">aigulj@audit.gov.mn</a><br>Аудитын менежер: Х.Женисбек<br>Утас: 70422930 Цахим хаяг: <a href="mailto:jenisbekh@audit.gov.mn">jenisbekh@audit.gov.mn</a><br>“Анализ старт аудит” ХХК-ийн захирал: Н.Энхтуяа<br>Утас:99075818 Цахим хаяг: <a href="mailto:asaudit.mn@gmail.com">asaudit.mn@gmail.com</a> |
|--|--|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **АГУУЛГА**

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
  2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
  3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
    - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....
    - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....
    - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....
    - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....
  4. Аудитын тайлан .....
  - 4.1 Ерөнхий зүйл .....
  - 4.2 Материаллаг байдал .....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....
5. Аудитын илрүүлэлт .....
  6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

### **Товчилсон үгийн жагсаалт**

|          |   |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС   | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт               |
| ТӨБЗГ    | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар                   |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgii@audit.gov.mn

ӨЛГИЙ СУМЫН 6 ДУГААР  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Х.СЕРТАЙ ТАНАА

2025.02.21 № 72  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлгий сумын 6 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Өлгий сумын 6 дугаар цэцэрлэг нь 2024 онд 990.5 сая төгрөгийн батлагдсан төсвөөр ажиллаж, гүйцэтгэлээр 904.8 сая төгрөг зарцуулж, 91.3 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

### Бусад асуудал

832502000109

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код   | Балансын үзүүлэлт  | Эхний үлдэгдэл                 | Эцсийн үлдэгдэл                |
|--------------|--|--------------------------------|--------------------------------|
| <b>1</b>     | <b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>   | <b><u>195,188,862.12</u></b>   | <b><u>172,043,383.12</u></b>   |
| <b>31</b>    | <b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>  | 119,394,714.00                 | 85,685,519.00                  |
| <b>312</b>   | <b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>  | 119,394,714.00                 | 85,685,519.00                  |
| <b>3121</b>  | <b>Төгрөг</b>  | 119,394,714.00                 | 85,685,519.00                  |
| <b>31211</b> | Төрийн сангийн харилцах  | 119,394,714.00                 | 85,685,519.00                  |
| <b>35</b>    | <b>БАРАА МАТЕРИАЛ</b>  | 75,794,148.12                  | 86,357,864.12                  |
| <b>354</b>   | <b>Хангамжийн материал</b>   | 75,794,148.12                  | 86,357,864.12                  |
| <b>35410</b> | Бичиг хэргийн материал   | 642,350.00                     | 442,000.00                     |
| <b>35420</b> | Аж ахуйн материал  | 1,966,054.00                   | 2,157,654.00                   |
| <b>35440</b> | Түлш, шатах тослох материал  | 153.00                         | 2,263,012.00                   |
| <b>35460</b> | Хүнсний материал   | 3,931,455.98                   | 408,622.98                     |
| <b>35470</b> | Бусад хангамжийн материал  | 69,254,135.14                  | 81,086,575.14                  |
| <b>2</b>     | <b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>                                       | <b><u>1,194,411,617.22</u></b> | <b><u>1,170,226,312.67</u></b> |
| <b>39</b>    | <b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>  | 1,194,411,617.22               | 1,170,226,312.67               |
| <b>392</b>   | <b>Биет хөрөнгө</b>  | 1,174,397,260.82               | 1,150,496,604.07               |
| <b>39201</b> | Барилга, байгууламж, орон сууц   | 1,198,492,702.00               | 1,202,936,035.00               |
| <b>39202</b> | Хуримтлагдсан элэгдэл  | (83,052,415.24)                | (106,902,462.88)               |
| <b>39205</b> | Машин тоног төхөөрөмж<br>(компьютер)                                     | 69,272,673.80                  | 74,981,673.80                  |
| <b>39206</b> | Хуримтлагдсан элэгдэл  | (30,629,142.71)                | (41,426,813.51)                |
| <b>39207</b> | Тавилга, аж ахуйн эд хогшил  | 50,992,348.49                  | 53,613,248.49                  |
| <b>39208</b> | Хуримтлагдсан элэгдэл  | (34,796,301.12)                | (36,822,472.43)                |
| <b>39217</b> | Ном  | 4,117,395.60                   | 4,117,395.60                   |
| <b>393</b>   | <b>Биет бус хөрөнгө</b>  | 20,014,356.40                  | 19,729,708.60                  |
| <b>39301</b> | Програм хангамж  | 1,973,239.00                   | 1,973,239.00                   |
| <b>39302</b> | Хуримтлагдсан элэгдэл  | (644,882.60)                   | (929,530.40)                   |
| <b>39303</b> | Бусад биет бус хөрөнгө   | 18,686,000.00                  | 18,686,000.00                  |
| <b>3</b>     | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>                                       | <b><u>1,389,600,479.34</u></b> | <b><u>1,342,269,695.79</u></b> |
| <b>4</b>     | <b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>  | <b><u>432,000.00</u></b>       | <b><u>2,431,500.00</u></b>     |
| <b>41</b>    | <b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>   | 432,000.00                     | 2,431,500.00                   |
| <b>413</b>   | <b>Өглөг</b>   | 432,000.00                     | 2,431,500.00                   |
| <b>4136</b>  | <b>Бусад өглөг</b>   | 432,000.00                     | 2,431,500.00                   |
| <b>41361</b> | Байгууллагад төлөх өглөг   | 432,000.00                     | 1,711,500.00                   |
| <b>41362</b> | Хувь хүмүүст төлөх өглөг   | -                              | 720,000.00                     |
| <b>5</b>     | <b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>  | <b><u>1,389,168,479.34</u></b> | <b><u>1,339,838,195.79</u></b> |
| <b>51</b>    | <b>Засгийн газрын хувь оролцоо</b>                                       | 1,389,168,479.34               | 1,339,838,195.79               |
| <b>511</b>   | Засгийн газрын оруулсан капитал<br>/Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 67,409,746.00                  | 67,409,746.00                  |
| <b>51101</b> | Өмч: - төрийн  | 67,409,746.00                  | 67,409,746.00                  |
| <b>512</b>   | <b>Хуримтлагдсан үр дүн</b>  | 1,292,809,007.46               | 1,243,478,723.91               |
| <b>51210</b> | Өмнөх үеийн үр дүн   | 1,223,764,481.15               | 1,292,809,007.46               |
| <b>51220</b> | Тайлант үеийн үр дүн   | 69,044,526.31                  | (49,330,283.55)                |

Өлгий сумын 6 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

|       |  |                                |                                |
|-------|--|--------------------------------|--------------------------------|
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү                   | 28,949,725.88                  | 28,949,725.88                  |
| 6     | <b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b> | <b><u>1,389,600,479.34</u></b> | <b><u>1,342,269,695.79</u></b> |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт  | Өмнөх оны гүйцэтгэл   | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|---|-----------------------|-----------------------|
| <b>1</b>   | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>                              | <b>771,246,439.00</b> | <b>890,369,973.00</b> |
| 12         | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>  | -                     | <b>19,284,773.00</b>  |
| 120        | <b>Нийтлэг татварын бус орлого</b>                                  | -                     | 19,284,773.00         |
| 120017     | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө                    |                       | 7,552,333.00          |
| 120018     | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал                    | -                     | 11,732,440.00         |
| 13         | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>                                | <b>771,246,439.00</b> | <b>871,085,200.00</b> |
| 1310       | <b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>                                      | 751,603,439.00        | 841,202,200.00        |
| 131001     | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт                                   | 722,044,200.00        | 841,202,200.00        |
| 131005     | Хөрөнгийн санхүүжилт  | 24,559,239.00         |                       |
| 131008     | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих                     | 5,000,000.00          |                       |
| 1320       | <b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>                               | 19,643,000.00         | 29,883,000.00         |
| 132001     | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 19,643,000.00         | 29,883,000.00         |
| <b>2</b>   | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>                                  | <b>702,201,912.69</b> | <b>939,700,256.55</b> |
| 21         | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>  | <b>702,201,912.69</b> | <b>939,700,256.55</b> |
| 210        | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                              | 702,201,912.69        | 939,700,256.55        |
| 2101       | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                            | 498,123,286.00        | 691,709,724.00        |
| 210101     | Үндсэн цалин  | 357,111,705.00        | 526,204,936.00        |
| 210102     | Нэмэгдэл  | 119,462,481.00        | 157,491,638.00        |
| 210104     | Урамшуулал  | 21,549,100.00         | 8,013,150.00          |
| 2102       | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>               | 63,265,725.00         | 86,742,271.00         |
| 210201     | Тэтгэврийн даатгал  | 41,986,974.00         | 59,244,126.54         |
| 210202     | Тэтгэмжийн даатгал  | 5,492,416.00          | 7,007,900.00          |
| 210203     | ҮОМШӨ-ний даатгал   | 4,394,213.00          | 3,458,548.62          |
| 210204     | Ажилгүйдлийн даатгал  | 1,090,271.00          | 3,458,548.62          |
| 210205     | Эрүүл мэндийн даатгал   | 10,301,851.00         | 13,573,147.22         |
| 2103       | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                    | 19,550,313.00         | 27,120,141.00         |
| 210301     | Гэрэл, цахилгаан  | 2,863,000.00          | 2,981,641.79          |
| 210302     | Түлш, халаалт   | 14,687,313.00         | 22,138,499.21         |
| 210303     | Цэвэр, бохир ус   | 2,000,000.00          | 2,000,000.00          |
| 2105       | <b>Нормативт зардал</b>   | 70,820,410.82         | 78,881,233.00         |
| 210502     | Хоол, хүнс  | 70,820,410.82         | 78,881,233.00         |
| 2108       | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>     | 840,000.00            | 2,358,000.00          |
| 210806     | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                     | 840,000.00            | 2,358,000.00          |
| 2109       | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                              | 49,602,177.87         | 52,888,887.55         |
| 210901     | Бараа үйлчилгээний бусад зардал                                     | 10,152,850.00         | 10,938,450.00         |

Өлгий сумын 6 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

|        |   |                             |                               |
|--------|---|-----------------------------|-------------------------------|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх         | 3,549,600.00                | 4,991,900.00                  |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол        | 35,899,727.87               | 36,958,537.55                 |
| 3      | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b> | <b><u>69,044,526.31</u></b> | <b><u>(49,330,283.55)</u></b> |
| 5      | <b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>            | <b><u>69,044,526.31</u></b> | <b><u>(49,330,283.55)</u></b> |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт  | Өмнөх оны гүйцэтгэл          | Тайлант оны гүйцэтгэл        |
|------------|---|------------------------------|------------------------------|
|            | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>                               |                              |                              |
| 1          | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>                       | <b><u>741,687,200.00</u></b> | <b><u>871,085,200.00</u></b> |
| 13         | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>                                | <b>741,687,200.00</b>        | <b>871,085,200.00</b>        |
| 1310       | <b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>                                      | 722,044,200.00               | 841,202,200.00               |
| 131001     | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт                                   | 722,044,200.00               | 841,202,200.00               |
| 1320       | <b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>                               | 19,643,000.00                | 29,883,000.00                |
| 132001     | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 19,643,000.00                | 29,883,000.00                |
| 2          | <b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>                        | <b><u>668,312,711.00</u></b> | <b><u>899,573,495.00</u></b> |
| 21         | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>  | <b>668,312,711.00</b>        | <b>899,573,495.00</b>        |
| 210        | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                              | <b>668,312,711.00</b>        | <b>899,573,495.00</b>        |
| 2101       | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                            | 498,123,286.00               | 690,853,395.00               |
| 210101     | Үндсэн цалин  | 357,111,705.00               | 509,691,327.00               |
| 210102     | Нэмэгдэл  | 119,462,481.00               | 173,148,918.00               |
| 210104     | Урамшуулал  | 21,549,100.00                | 8,013,150.00                 |
| 2102       | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>               | 63,265,725.00                | 87,598,600.00                |
| 210201     | Тэтгэврийн даатгал  | 41,986,974.00                | 59,567,100.00                |
| 210202     | Тэтгэмжийн даатгал  | 5,492,416.00                 | 7,007,900.00                 |
| 210203     | ҮОМШӨ-ний даатгал   | 4,394,213.00                 | 3,503,900.00                 |
| 210204     | Ажилгүйдлийн даатгал  | 1,090,271.00                 | 3,503,900.00                 |
| 210205     | Эрүүл мэндийн даатгал   | 10,301,851.00                | 14,015,800.00                |
| 2103       | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                    | 19,143,000.00                | 29,383,000.00                |
| 210301     | Гэрэл, цахилгаан  | 2,863,000.00                 | 3,863,000.00                 |
| 210302     | Түлш, халаалт   | 14,280,000.00                | 23,520,000.00                |
| 210303     | Цэвэр, бохир ус   | 2,000,000.00                 | 2,000,000.00                 |
| 2105       | <b>Нормативт зардал</b>   | 74,052,200.00                | 72,926,900.00                |
| 210502     | Хоол, хүнс  | 74,052,200.00                | 72,926,900.00                |
| 2106       | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                            | 500,000.00                   | 500,000.00                   |
| 210604     | Урсгал засвар   | 500,000.00                   | 500,000.00                   |
| 2108       | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>     | 840,000.00                   | 2,358,000.00                 |

Өлгий сумын 6 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

|        |  |                              |                               |
|--------|--|------------------------------|-------------------------------|
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ  | 840,000.00                   | 2,358,000.00                  |
| 2109   | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                                     | 12,388,500.00                | 15,953,600.00                 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал  | 9,061,700.00                 | 11,302,300.00                 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх  | 3,326,800.00                 | 4,651,300.00                  |
| 3      | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>                    | <b><u>73,374,489.00</u></b>  | <b><u>(28,488,295.00)</u></b> |
| 5      | <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>                           | <b>3,465,400.00</b>          | <b>5,220,900.00</b>           |
| 22     | <b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>  | <b>3,465,400.00</b>          | <b>5,220,900.00</b>           |
| 2200   | <b>Дотоод эх үүсвэрээр</b>   | 3,465,400.00                 | 5,220,900.00                  |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал                             | 3,465,400.00                 | 5,220,900.00                  |
| 6      | <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b> | <b><u>(3,465,400.00)</u></b> | <b><u>(5,220,900.00)</u></b>  |
| 8      | <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>                           | 69,909,089.00                | (33,709,195.00)               |
| 9      | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>                    | 49,485,625.00                | 119,394,714.00                |
| 10     | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>                   | 119,394,714.00               | 85,685,519.00                 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт  | Өмнөх оны             |                       | Тайлант оны           |                       |
|-----------------------|---|-----------------------|-----------------------|-----------------------|-----------------------|
|                       |   | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл             | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл             |
| 2                     | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>              | <b>741,687,200.00</b> | <b>671,778,111.00</b> | <b>990,479,900.00</b> | <b>904,794,395.00</b> |
| 21                    | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                  | 741,687,200.00        | 671,778,111.00        | 990,479,900.00        | 904,794,395.00        |
| 210                   | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                | 741,687,200.00        | 671,778,111.00        | 990,479,900.00        | 904,794,395.00        |
| 2101                  | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>              | 576,649,600.00        | 498,123,286.00        | 767,705,900.00        | 690,853,395.00        |
| 210101                | Үндсэн цалин  | 362,971,900.00        | 357,111,705.00        | 570,481,900.00        | 509,691,327.00        |
| 210102                | Нэмэгдэл  | 192,834,200.00        | 119,462,481.00        | 188,123,000.00        | 173,148,918.00        |
| 210104                | Урамшуулал  | 20,843,500.00         | 21,549,100.00         | 9,101,000.00          | 8,013,150.00          |
| 2102                  | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b> | 75,676,000.00         | 63,265,725.00         | 90,288,100.00         | 87,598,600.00         |
| 210201                | Тэтгэврийн даатгал                                    | 51,459,800.00         | 41,986,974.00         | 61,397,500.00         | 59,567,100.00         |

Өлгий сумын 6 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

|        |   |                       |                       |                       |                       |
|--------|---|-----------------------|-----------------------|-----------------------|-----------------------|
| 210202 | Тэтгэмжийн даатгал  | 6,053,900.00          | 5,492,416.00          | 7,221,600.00          | 7,007,900.00          |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал   | 4,843,300.00          | 4,394,213.00          | 3,611,400.00          | 3,503,900.00          |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал  | 1,211,000.00          | 1,090,271.00          | 3,611,400.00          | 3,503,900.00          |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал   | 12,108,000.00         | 10,301,851.00         | 14,446,200.00         | 14,015,800.00         |
| 2103   | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                | 19,143,000.00         | 19,143,000.00         | 29,383,000.00         | 29,383,000.00         |
| 210301 | Гэрэл, цахилгаан  | 2,863,000.00          | 2,863,000.00          | 3,863,000.00          | 3,863,000.00          |
| 210302 | Түлш, халаалт   | 14,280,000.00         | 14,280,000.00         | 23,520,000.00         | 23,520,000.00         |
| 210303 | Цэвэр, бохир ус   | 2,000,000.00          | 2,000,000.00          | 2,000,000.00          | 2,000,000.00          |
| 2105   | <b>Нормативт зардал</b>   | 52,502,500.00         | 74,052,200.00         | 74,967,000.00         | 72,926,900.00         |
| 210502 | Хоол, хүнс  | 52,502,500.00         | 74,052,200.00         | 74,967,000.00         | 72,926,900.00         |
| 2106   | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                        | 500,000.00            | 500,000.00            | 500,000.00            | 500,000.00            |
| 210604 | Урсгал засвар   | 500,000.00            | 500,000.00            | 500,000.00            | 500,000.00            |
| 2108   | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b> | 1,108,900.00          | 840,000.00            | 2,586,100.00          | 2,358,000.00          |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                 | 1,108,900.00          | 840,000.00            | 2,586,100.00          | 2,358,000.00          |
| 2109   | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                          | 16,107,200.00         | 15,853,900.00         | 25,049,800.00         | 21,174,500.00         |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал                                 | 12,780,400.00         | 12,527,100.00         | 17,798,500.00         | 13,923,200.00         |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                               | 3,326,800.00          | 3,326,800.00          | 7,251,300.00          | 7,251,300.00          |
| 13     | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                           | <b>741,687,200.00</b> | <b>671,778,111.00</b> | <b>990,479,900.00</b> | <b>871,085,200.00</b> |
| 1310   | <b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                                  | 722,044,200.00        | 652,135,111.00        | 841,202,200.00        | 841,202,200.00        |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих   | 722,044,200.00        | 652,135,111.00        | 841,202,200.00        | 841,202,200.00        |
| 1320   | <b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                           | 19,643,000.00         | 19,643,000.00         | 29,883,000.00         | 29,883,000.00         |
| 132001 | Орон нутгийн төсвөөс  | 19,643,000.00         | 19,643,000.00         | 29,883,000.00         | 29,883,000.00         |
| 4      | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>         |                       |                       |                       | 119,394,714.00        |
| 5      | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>        |                       | <b>119,394,714.00</b> |                       | 85,685,519.00         |

Өлгий сумын 6 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

## **2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

*Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар*

Өлгий сумын 6 дугаар цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсрол олгох чиг үүрэгтэй байгууллага юм. Тус цэцэрлэг нь 2024 онд "Цэцэрлэгийн менежментийг сайжруулж, хүүхдийн бүх талын оролцоо, хамтын ажиллагааг хангаж, сургалтын үйл ажиллагааны чанар, үр дүнг сайжруулах" гэсэн зорилготой ажиллаж, 8 зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

*Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар*

Өлгий сумын 6 дугаар цэцэрлэг нь Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг зарим хууль тогтоомж, бодлого чиглэлд өөрчлөлтүүд орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Боловсролын ерөнхий газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас санхүүгийн баримтын шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлгий сумын 6 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Цэцэрлэгчийн эрхлэгчийн 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/13 тоот тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ашигладаг бөгөөд уг баримт бичгийг шинээр гарсан хууль эрхийн актуудтай нийцүүлэн шинэчлэх шаардлагатай байна.

#### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Өлгий сумын 6 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2023 оны 229 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Өлгий сумын 6 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 47.3 сая төгрөгөөр буюу 0.34 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт                                     | /мянган төгрөгөөр/  |                     |                    |
|--|---------------------|---------------------|--------------------|
|  | Эхний үлдэгдэл      | Эцсийн үлдэгдэл     | Өөрчлөлт           |
| Б  | 1                   | 2                   | 3=2-1              |
| Мөнгөн хөрөнгө                               | 119,394.71          | 85,685.52           | (33,709.20)        |
| Авлага                                       | -                   | -                   | -                  |
| Урьдчилгаа                                   | -                   | -                   | -                  |
| Бараа материал                               | 75,794.15           | 86,357.86           | 10,563.72          |
| Үндсэн хөрөнгө                               | 1,194,411.62        | 1,170,226.31        | (24,185.30)        |
| <b>Нийт хөрөнгө</b>                          | <b>1,389,600.48</b> | <b>1,342,269.70</b> | <b>(47,330.78)</b> |
| Өр төлбөр                                    | 432.00              | 2,431.50            | 1,999.50           |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/     | 1,389,168.48        | 1,339,838.20        | (49,330.28)        |
| <b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b> | <b>1,389,600.48</b> | <b>1,342,269.70</b> | <b>(47,330.78)</b> |

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бараа материал дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгө оны эцэст 85.7 сая төгрөг үлдэгдэлтэй гарч, оны эхнээс 33.7 сая төгрөгөөр буурсан байна. Цалингийн зардал болон, нийгмийн даатгалын шимтгэлээс 81.9 сая төгрөг, хүүхдийн хоолны зардлаас 2.0 сая төгрөг, бараа, үйлчилгээний зардлаас 1.8 сая төгрөг зарцуулагдаагүй үлдсэн байна.

Бараа материал данс оны эцэст 86.4 сая төгрөг болж, оны эхнээс 10.5 сая төгрөгөөр өссөн байна. Бичиг хэргийн материал 0.4 сая төгрөгийн, Аж ахуйн материал 2.2 сая төгрөгийн Хүнсний материал 0.4 сая төгрөгийн, түлш 2.3 сая төгрөгийн, бусад хангамжийн материал 81.1 сая төгрөгийн төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1 170.2 сая төгрөг болж, 24.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 5.2 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан, үнэ төлбөргүй хүлээн авсан 7.6 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, үндсэн хөрөнгөд 149.1 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Өр төлбөр данс оны эцэст 2.4 сая төгрөг болж, оны эхнээс 2.0 сая төгрөгөөр өссөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1 339.8 сая төгрөг болж, 49.3 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 49.3 сая төгрөгийн алдагдалтай гарснаас шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Цэцэрлэгийн 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 660.3 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 29.9 сая төгрөг, нийт зарлагыг 690.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас цэцэрлэгийн 2024 оны хувьсах зардлын төсвийг 615.9 сая төгрөгөөр хянаж, 44.5 сая төгрөгөөр бууруулан баталсан ба төсвийн тодотголоор 300.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 960.6 сая төгрөг болгон тодотгон баталжээ.

Өлгий сумын 6 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Орон нутгийн төсвөөс авах тогтмол зардлын төсвийг 29.9 сая төгрөгөөр хянаж, 5.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан ба тодотгол хийгдээгүй байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 960.6 сая төгрөгийг улсын төсвөөс, 29.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, нийтдээ 990.5 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 841.2 сая, орон нутгийн төсвөөс 29.9 сая, нийт 871.1 сая төгрөгийн санхүүжилт авч, оны эхний үлдэгдлээс 119.3 сая төгрөг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 904.8 сая төгрөг болж, 91.3 хувийн биелэлттэй, 85.7 сая төгрөгийн дансны үлдэгдэлтэй гарсан байна. Төсвийн харилцах дансанд их хэмжээний мөнгөний үлдэгдэлтэй гарсан нь төсвийн төлөвлөлт, хуваарилалттай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/ төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр арга хэмжээний нэр                                   | Код   | Төлөвлөгөө | Гүйцэтгэл  | Зөрүү     | Хувь   |
|-----|---|-------|------------|------------|-----------|--------|
| 1   | Хүүхэд хамгаалах  | 80233 | 1,088.10   | 1,088.10   | -         | 100.0% |
| 2   | Эрүүл мэндийг дэмжих  | 81605 | 1,847.30   | 1,847.30   | -         | 100.0% |
| 3   | Цэцэрлэгийн хүүхдийн хоол                                     | 81807 | 74,967.00  | 72,926.90  | 2,040.10  | 97.3%  |
| 4   | Хүүхдэд ээлтэй сургалтын орчин                                | 81816 | 2,620.90   | 2,620.90   | -         | 100.0% |
| 5   | Боловсролын байгууллагын багш ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх | 81823 | 1,752.80   | -          | 1,752.80  | 0.0%   |
| 6   | Боловсролын стандарт, сургалтын үйл ажиллагаа                 | 81834 | 878,320.80 | 796,428.20 | 81,892.61 | 90.7%  |
| 7   | Нийтлэг үйлчилгээ ОН  |       | 29,883.00  | 29,883.00  |           |        |
|     | Нийт дүн  |       | 990,479.90 | 904,794.40 | 85,685.51 | 91.3%  |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Санхүү-нийцлийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлийн судалгааны дүн дараах байдалтай байна. Үүнд:

Өлгий сумын 6 дугаар цэцэрлэг нь Ахмадын тухай хууль, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор баталсан “Ахмадын сан ажиллуулах журам”-ыг хэрэгжүүлээгүй буюу ахмадын сан байгуулж ажиллаагүй байна.

Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө баталж ажиллаагүй байна.

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлаас 2.4 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлын дансаар 15.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

Байгууллагын 2024 оны орон тооны судалгааг гаргуулан авч хянаж үзэхэд Боловсрол, шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын 2024 оны А/85, А/34 дүгээр хамтарсан тушаалаар баталсан хүүхдийн цэцэрлэгийн багш, ажилтны орон тооны хязгаарын жишиг нормативыг баримтлан ажиллаж байна.

Тус цэцэрлэгийн 1-12 дугаар сарын цалин олгох хүснэгтээр 36 хүнд цалин хөлс олгосон байна.

Өлгий сумын 6 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Цэцэрлэг нь тайлант онд нэмэлт төсөв аваагүй байна.

### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Өлгий сумын 6 дугаар цэцэрлэгт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүд байхгүй байна.

### **3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Өлгий сумын 6 дугаар цэцэрлэг нь 2024 онд 111.5 сая төгрөгийн бараа материал, 5.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Өлгий сумын 6 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Анализ старт аудит” ХХК-ийн аудитор Ц.Оюунтуул, шинжээч Д.Энхцаг нар гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг компанийн захирал Н.Энхтуяа, дараагийн шатны хяналтыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Өлгий сумын 6 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Анализ старт аудит” ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 40 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Өлгий сумын 6 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 702.2 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 7.9 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай /*ӨМНӨХ ОНООС УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ 29.7 ХУВИАР ӨССӨН*/ гэж үзсэн учир 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 939.7 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 10.6 сая төгрөгөөр тогтоосон.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 29 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлэхэд алдаа, зөрчил илрээгүй.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгахад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг бүрэн мэдээлсэн байна.

##### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн төсвийн зарцуулалт нь Төсвийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Өлгий сумын 6 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланд завсарын аудит хийхэд, дансны код сонголт, цалингийн бичилттэй холбоотой 27.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнд зөвлөмж өгч, үйлчлүүлэгч байгууллагад Асуудлын бүртгэлээр хүргүүлсэн ба 27.1 сая төгрөгийн алдааг залруулсан байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгөгдсөнийг хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт |          | Биелэлт |          |       |
|----------|------------------------|----------|---------|----------|-------|
|          | Тоо                    | Дүн      | Тоо     | Дүн      | Хувь  |
| Зөвлөмж  | 1                      | 15 300.0 | 1       | 15 300.0 | 100.0 |
| Нийт дүн | 1                      | 15 300.0 | 1       | 15 300.0 | 100.0 |

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Аудитаар нийт 4.0 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 4.0 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

Бичигдээгүй.

### 5.2 Албан шаардлага

1.Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 2/2772 дугаартай “Төсвийн шууд захирагч нарт” албан бичгээр 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар “Өөрчлөлтгүй дүгнэлт” авсан төсөв, санхүүгийн ажилтан нарт балансын урамшууллыг олгож болно гэснийг үндэслэн, цэцэрлэгийн эрхлэгчийн 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн А/04 дугаар тушаалаар 3,9840.0 мянган төгрөгийн урамшуулал олгож, төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын хэмжээг хэтрүүлсэн байна.

2.Ажилтнуудад ур чадварын нэмэгдэл олгохдоо шалгуур үзүүлэлтээр дүгнэж олгосон боловч уг үзүүлэлт нь Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны А/35, А/10, 9, Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 1996 оны 63/104 тушаалаар батласан шалгуур үзүүлэлттэй нийцэхгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2 "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" заалт, ажилтнуудад ур чадварын нэмэгдэл олгохдоо шалгуур үзүүлэлтээр дүгнэж олгосон боловч уг үзүүлэлт нь Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны А/35, А/10, 9, Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 1996 оны 63/104 тушаалаар батласан шалгуур үзүүлэлттэй нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн албан хаагчид олгох мөнгөн урамшуулалыг холбогдох хууль, журам зөрчиж, тогтоосон хэмжээнээс хэтрүүлэн олгохгүй байх., ур чадварын нэмэгдлийг холбогдох шалгуур үзүүлэлтээр дүгнэж олгож байх талаар албан шаардлага өгөв.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилттэй холбоотой асуудал

##### 1.1 Илрүүлэлт:

Цэцэрлэг нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлээгүй /хоол хүнсний зардал 74.9 сая төгрөг, худалдан авсан үндсэн хөрөнгө 5.2 сая төгрөг г.м/ байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44.1-т Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.”, 46.1-т “Захиалагч худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүнг тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан төсөл, арга хэмжээ бүрээр харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр тайлагнана.” гэсэн заалттай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өлгий сумын 6 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**2.2 Өгсөн зөвлөмж:** Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлж ажиллах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга   | Нийт зөрчил |                | Үүнээс        |     |                 |                |          |          |                                      |                     |   |     |  |
|--|-------------|----------------|---------------|-----|-----------------|----------------|----------|----------|--------------------------------------|---------------------|---|-----|--|
|  |             |                | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |                | Зөвлөмж  |          | Хариуцлага тооцуулах албан шаардлага |                     | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |     |  |
|  | Тоо         | Дүн            | Тоо           | Дүн | Тоо             | Дүн            | Тоо      | Дүн      | Тоо                                  | Албан тушаалтны тоо | Тоо   | Дүн |  |
| Урамшуулал, ур чадварын нэмэгдэлтэй холбоотой                | 1           | 3,984.0        |               |     | 1               | 3,984.0        |          |          |                                      |                     |   |     |  |
| Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, тайлагнаагүй. | 1           | 0              |               |     |                 |                | 1        | 0        |                                      |                     |   |     |  |
| <b>Дүн</b>   | <b>2</b>    | <b>3,984.0</b> |               |     | <b>1</b>        | <b>3,984.0</b> | <b>1</b> | <b>0</b> |                                      |                     |   |     |  |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга                                       | Нийт зөрчил |     | Үүнээс        |     |                 |     |         |     |
|--|-------------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|
|  |             |     | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж |     |
|  | Тоо         | Дүн | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо     | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил |             |     |               |     |                 |     |         |     |
|  |             |     |               |     |                 |     |         |     |
|  |             |     |               |     |                 |     |         |     |
| <b>Дүн</b>   |             |     |               |     |                 |     |         |     |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил                 |             |     |               |     |                 |     |         |     |
|  |             |     |               |     |                 |     |         |     |
| <b>Нийт дүн</b>  |             |     |               |     |                 |     |         |     |